



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/214

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “н”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэд сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, уул уурхайн ашиглалтын улмаас эвдэгдсэн газрын хэмжээг шинэчлэн тогтсох, нөхөн сэргээлтийг хариуцах эрх бүхий этгээдээр нь гүйцэтгүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга


Гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Сумдын Засаг дарга

2. Зохион байгуулагдаж буй “Нөхөн сэргээлт-2020” арга хэмжээнд шаардлагатай судалгаа, мэдээллийг дээд шатны байгууллагуудаар батлагдсан төлөвлөгөөний дагуу үр дүнтэй шуурхай зохион байгуулж, холбогдох тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлээгүй бол тусгай дансанд байршуулсан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430091791